



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-ийн заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа зочид буудал, дэн буудлуудад үйлчилгээний технолги, стандарт сурталчилах сургалт зохион байгуулахыг үйлчилгээний байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Ганболд/, мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/ нарт үүрэг болгосугай.

Хоёр. Сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


Гурав. Сургалтанд зарцуулагдах 780.000 /долоон зуун наян мянга/ төгрөгийг хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Сургалтыг цаг хугацаанд нь зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг үйлчилгээний байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Ганболд/, мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/ нарт даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР



**УЛААНБААТАР ХОТЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДАД СУРГАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Улаанбаатар хот

2012 оны 09 дүгээр сар 26

Нэг. Үндэслэл

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд болох зочид буудал, дэн буудлуудын үйл ажиллагааны өгнөөгийн түвшин, ажилчдын ур чадвар хангалттай түвшинд байж чанахгүй байгаа нь удаа дараагын шалгалт судлагааны үр дүнгээс харагдаж байна. Тиймээс үйлчилгээний технолги, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах шаардлага үүсээд байна.

Хоёр. Зорилго

Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний соёл, аюулгүй ажиллагааны түвшинг дээшлүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино. Мөн 2012 оны 10-р сард зохион байгуулагдах зочид буудал, дэн буудлуудын аттестатчилалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгч ажиллана.

Гурав. Хүрэх үр дүн

Энэхүү сургалтыг зохион байгуулсанаар аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын ажилчдын мэргэжлийн ур чадвар дээшлэнэ. Мөн Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын удирдлагуудын үйлчилгээний соёл болон аялал жуулчлалын үйлчилгээний технолгийн талаарх мэдлэг мэдээлэл дээшилнэ. Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж байгаа хууль дүрэм журам болон арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийг түгээнэ.

Дөрөв. Сургалтын агуулга

Өмнөх жилүүдэд хийгдэж байсан сургалт, семинарууд болон судлагаа, шалгалт аттестатчилалын үр дүнг үндэслэн сургалтыг дараах үндсэн чиглэлүүдээр зохион байгуулана. Үүнд:

- Зочин хүлээн авах хэсгийн үйл ажиллагааны технолги
- Өрөөний үйлчилгээний үйл ажиллагааны технолгои

- Эрүүл ахуй, цэвэрлэгээ үйлчилгээний технологи
- Аюулгүй ажиллагаанд анхаарах зүйлс

Тав. Хамрах хүрээ

Сургалтанд улаанбаатар хотын найман /Багахангай дүүрэгт одоогоор зочид буудал, дэн буудал бүртгэгдээгүй байгаа/ дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа бүх зочид буудал дэн буудлуудыг хамруулна.

Зургаа. Хугацаа

Сургалтыг 2012 оны 10дүгээр сарын 01-03-ны өдрүүдэд зохион байгуулна.

Долоо. Зохион байгуулалт

Сургалтыг дүүрэг бүрээр салгаж зохион байгуулах бөгөөд нэг өдөрт 2 дүүрэгийг зэрэг зохион байгуулахаар тооцоолж дүүргүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр дараах хуваарийг гаргалаа. Үүнд:

Огноо	Дүүргүүд	Болох газар
2012 оны 9 дүгээр сар 24	Баянгол	Нью вэст зочид буудал
	Сонгино хайрхан	ТНТ зочид буудал
2012 оны 9 дүгээр сар 25	Сүхбаатар	Пума Имериал зочид буудал
	Чингэлтэй	Хараа Зочид буудал
2012 оны 9 дүгээр сар 26	Баянзүрх	Чингис хаан зочид буудал
	Хан Уул	Палас зочид буудал
2012 оны 9 дүгээр сар 28	Багануур, Налайх	Хангарьд ордон



УЛААНБААТАР ХОТЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДАД СУРГАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ТӨСӨВ

д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Нийт өртөг
	Заалны түрээс	Өдрөөр	3*200.000	600.000
	Багшийн ажлын хөлс	Өдрөөр	7*3=21*35.000	735.000
	Гарын авлага бэлдэж олшруулах	400ш	5.000	2.000.000
	Цай кофе	400ш	1.500	600.000
	Цэвэр ус	400ш	450	180.000
	Бичгийн хэрэгсэл	400ш	1.200	480.000
	Нийт төсөв			4.595.000


ТӨСӨВ ЗОХИОСОН:

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

 Д.ГАНБОЛД

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ



П.АРИУНАА